



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 437

Улаанбаатар хот

Аргачлал шинэчлэн батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийг боловсруулах аргачлал, хэрэгжилтийг тайлагнах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэлтийн ажлыг үнэлэх аргачлал”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан аргачлалыг үүрэг хүлээсэн хэрэглэгчдэд мэдэгдэх, эрчим хүч хэмнэлтийн ажлыг шинэчлэгдсэн аргачлалын дагуу үнэлж, үр дүнг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд танилцуулахыг Эрчим хүч хэмнэлтийн газар (А.Бат-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Аргачлал батлах тухай” 2021 оны 478 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Б.Болор-Эрдэнэ)-нд даалгасугай.

ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ


Э.ТҮВШИНЧУЛУУН

П.ТОВУУДОРЖ

Л.ДАШМЯГМАРЖАВ

Ц.НОРОВЖАМЦ

Д.ЦОГОО



• 230001822

Эрчим хүчний зохицуулах хорооны
2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн
737 дугаар тогтоолын хавсралт



ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН АЖЛЫГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ аргачлалын зорилго нь үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх хөтөлбөр, төлөвлөгөө, тайланг боловсруулах, хэрэгжүүлэхэд хяналт тавих, биелэлтийг үнэлж, дүгнэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Зөрчлийн тухай, “Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийг боловсруулах аргачлал, хэрэгжилтийг тайлагнах журам” болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

1.3. Энэхүү аргачлалыг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл, үүрэг хүлээсэн хэрэглэгч дагаж мөрдөнө.

1.4. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүн, хууль тогтоомжийн хэрэгжилтийг энэхүү аргачлалын дагуу үнэлж, Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл нь үнэлгээ, нэгдсэн дүнг хэлэлцэж баталгаажуулна.

Хоёр. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэлтийн ажлын тайланг үнэлэх

2.1. “Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийг боловсруулах аргачлал, хэрэгжилтийг тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан үүрэг буюу эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг хавсралтад заасан “Дүгнэх үзүүлэлт”-ийн дагуу жил бүр дүгнэнэ.

2.2. Үүрэг хүлээсэн хэрэглэгч нь эрчим хүч хэмнэлтийн ажил, арга хэмжээний жилийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлан, тайлангийн дэлгэрэнгүйг батлагдсан маягтын дагуу боловсруулж, байгууллагын удирдлага болон эрчим хүч хэмнэлтийн менежерээр баталгаажуулан “Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийг боловсруулах аргачлал, хэрэгжилтийг тайлагнах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан хугацаанд албан бичгээр болон цахим системээр Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлнэ.

2.3. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэлтийн ажлыг энэ аргачлалын хавсралтад заасан “Дүгнэх үзүүлэлт”-ээр үнэлэх бөгөөд хугацаа нь болоогүй ажлын харгалзах оноог бүрэн тооцно.

2.4. Энэ аргачлалын хавсралтад заасан үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн ажлуудын нийт дүнг дараах байдлаар үнэлэх бөгөөд үнэлэхдээ үйл ажиллагааны бодит нөхцөлийг харгалзан үзнэ.

Оноо (%)	Үнэлгээ
90-100 хүртэл	Хангалттай сайн
75-90 хүртэл	Сайн
60-75 хүртэл	Дунд
0-60 хүртэл	Хангалтгүй

2.5. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэлтийн ажлын дүнг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөл хэлэлцэж, үнэлгээг тогтоолоор баталж үүрэг хүлээсэн хэрэглэгчид мэдэгдэнэ.

2.6. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэлтийн ажлын хэрэгжилт, үр дүнг баталгаажуулах зорилгоор явцын болон гүйцэтгэлийн хяналт хийх ажлыг зохион байгуулж болно.

2.7. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэлтийн ажлын үнэлгээний нэгдсэн дүнг цахим системд байршуулна.

2.8. “Дунд” үнэлэгдсэн үүрэг хүлээсэн хэрэглэгчид эрчим хүчний хэмнэлтийн ажлыг эрчимжүүлэх мэргэжил арга зүйн зөвлөмж, чиглэл өгч ажиллана.

2.9. “Хангалтгүй” үнэлэгдсэн үүрэг хүлээсэн хэрэглэгчид Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэлтийн ажлыг үнэлэх аргачлалын хавсралт

Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэлтийн ажлыг дүгнэх үзүүлэлт

№	Эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр хэрэгжүүлэх ажил	Дүгнэх оноо	Дүгнэх зарчим	Хууль, журмын үндэслэл
1.	Эрчим хүч хэмнэлтийн менежерийг мэдэгдэл авснаас хойш 3 сарын дотор томилон ажиллуулах;	5	- хугацаандаа томилсон бол 5 оноогоор дүгнэнэ. - хугацаанаас хэтэрч томилсон бол 2 оноо хасаж тооцно. - томилоогүй бол оноо өгөхгүй.	Хуулийн ¹ 10.2.5, журмын ² 3.1.1
2.	Эрчим хүч хэмнэлтийн менежерийг томилсон, чөлөөлсөн талаар Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд 14 хоногийн дотор бичгээр мэдэгдэх;	3	- менежер томилсон, чөлөөлсөн тухай хугацаандаа мэдэгдсэн бол 3 оноогоор дүгнэнэ. - менежер томилсон, чөлөөлсөн тухай хугацаандаа мэдэгдээгүй бол оноо өгөхгүй.	Хуулийн ¹ 10.2.5, журмын ² 3.1.4
3.	Эрчим хүч хэмнэлтийн менежер (ЭХХМ)-ийг сургалтад хамруулах хүсэлтийг эрчим хүч хэмнэлтийн менежерийг томилсноос хойш 14 хоногийн дотор Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд ирүүлэх;	4	- ЭХХМ-ийн сургалтад хамрагдаж эрх авсан, сургалтад хамрагдах бүртгэл хийлгэсэн бол 4 оноогоор дүгнэнэ. - ЭХХМ-ийн сургалтад хугацаандаа хамрагдаагүй, эрх аваагүй, сургалтад хамрагдах бүртгэл хийлгээгүй бол оноо өгөхгүй.	Хуулийн ¹ 15.1, 15.2.5, журмын ² 3.1.5
4.	Эрчим хүч хэмнэлтийн менежерийг ажиллах нөхцөл, бололцоогоор хангах;	3	- Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс зохион байгуулж байгаа мэргэшүүлэх сургалтад хамрагдсан бол 3 оноогоор дүгнэнэ. - Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлөөс зохион байгуулж байгаа мэргэшүүлэх сургалтад хамрагдаагүй бол оноо өгөхгүй.	Хуулийн ¹ 15.1, 15.2, журмын ² 3.1.6
5.	Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, эрчим хүчний хэрэглээний мэдээллийг холбогдох маягт, загварын дагуу гаргаж, 6 сарын дотор Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх;	5	- мэдээллийг заасан хугацаанд ирүүлсэн бол 5 оноогоор дүгнэнэ. - мэдээллийг заасан хугацаанд ирүүлээгүй бол оноо өгөхгүй.	Хуулийн ¹ 10.2.1, 9.1.3, журмын ² 3.1.3
6.	Эрчим хүчний хэрэглээ, энергийн урсгалыг (баланс) тодорхойлох зорилгоор хэмжүүржүүлэх;	10	- хэмжүүржүүлсэн бол 10 оноогоор дүгнэнэ. - хэмжүүржүүлээгүй бол оноо өгөхгүй.	Хуулийн ¹ 10.2.1, журмын ² 3.1.2

	<p>Эрчим хүчний анхан шатны аудитыг 18 сарын дотор, цаашид хэсэгчилсэн эсхүл, дэлгэрэнгүй аудит хийлгэх ба аудит хоорондын хугацаа 36 сараас хэтрэхгүй байх; (барилга байгууламж өмчлөгч, эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллага ангиллын үүрэг хүлээсэн хэрэглэгч нь барилгын эрчим хүчний хэрэглээний гэрчилгээг 12 сарын дотор эрчим хүчний анхан шатны аудит хийлгэх замаар авах)</p>	<p>5</p>	<ul style="list-style-type: none"> - аудит хийлгэсэн бол 5 оноогоор дүгнэнэ. - аудит хийлгээгүй бол оноо өгөхгүй. - аудитын тайланг 14 хоногийн дотор Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд ирүүлсэн бол 5 оноогоор дүгнэнэ. - аудитын тайланг 14 хоногийн дотор Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд ирүүлээгүй бол оноо өгөхгүй. - аудитын зөвлөмжийн дагуу эрчим хүч хэмнэх хөтөлбөрийг журмын² 4.3, 4.4-т заасны дагуу боловсруулсан бол 5 оноогоор дүгнэнэ. - аудитын зөвлөмжийн дагуу эрчим хүч хэмнэх хөтөлбөрийг журмын² 4.3, 4.4-т заасны дагуу боловсруулаагүй бол оноо өгөхгүй. - аудитын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл ирүүлсэн бол 5 оноогоор дүгнэнэ. - аудитын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл ирүүлээгүй бол оноо өгөхгүй. 	<p>Хуулийн¹ 10.2.2, 10.2.3, 10.2.4, журмын² 3.1.7, 3.1.8, 4.1, 4.2, 4.3, 4.4, 5.3</p>
<p>7.</p>	<p>Эрчим хүч хэмнэлтийн тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээг баталж, хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах.</p>	<p>5</p>	<ul style="list-style-type: none"> - тухайн жилийн төлөвлөгөөг журмын 4.5, 4.6-д заасны дагуу боловсруулж хугацаандаа ирүүлсэн бол 5 оноогоор дүгнэнэ. - тухайн жилийн төлөвлөгөөг журмын 4.5, 4.6-д заасны дагуу боловсруулаагүй, хугацаандаа ирүүлээгүй бол оноо өгөхгүй. - тухайн жилийн тайланг хугацаандаа ирүүлсэн бол 5 оноогоор дүгнэнэ. - тухайн жилийн тайланг хугацаандаа ирүүлээгүй бол оноо өгөхгүй. - эрчим хүч хэмнэлтийн тухайн жилийн хүрэх үр дүнг энерги, мөнгөн дүнгээр тооцсон бол 5 оноогоор дүгнэнэ. - эрчим хүч хэмнэлтийн тухайн жилийн хүрэх үр дүнг энерги, мөнгөн дүнгээр тооцоогүй бол оноо өгөхгүй; - эрчим хүч хэмнэлтийн тухайн жилийн хүрсэн үр дүнг энерги, мөнгөн дүнгээр тооцсон бол 15 оноогоор дүгнэнэ. 	<p>Хуулийн¹ 10.2.3, 10.2.4, журмын² 3.1.9, 4.4, 4.5, 4.6, 5.1, 5.2</p>
<p>8.</p>		<p>15</p>		

			<ul style="list-style-type: none"> - эрчим хүч хэмнэлтийн тухайн жилийн хүрсэн үр дүнг энерги, мөнгөн дүнгээр тооцоогүй бол оноо өгөхгүй; - тайланд эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр хийгдсэн ажлын нотлох баримтыг хавсаргасан бол 10 оноогоор дүгнэнэ. - тайланд эрчим хүч хэмнэлтийн чиглэлээр хийгдсэн ажлын нотлох баримтыг хавсаргаагүй бол оноо өгөхгүй. - сургалт, сурталчилгаа зохион байгуулсан бол 10 оноогоор дүгнэнэ. - сургалт, сурталчилгаа зохион зохион байгуулаагүй бол оноо өгөхгүй.
10			<ul style="list-style-type: none"> - сургалт, сурталчилгаа зохион байгуулсан бол 10 оноогоор дүгнэнэ. - сургалт, сурталчилгаа зохион зохион байгуулаагүй бол оноо өгөхгүй.
Төлөвлөгөө, тайланг удирдлагаар баталгаажуулаагүй бол үнэлгээ өгөхгүй.			
НИЙТ ДҮН			100

Тайлбар:

¹ хууль гэж Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль

² журам гэж Засгийн газрын 2019 оны 181-р тогтоолоор баталсан “Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийг боловсруулах аргачлал, хэрэгжилтийг тайлагнах журам”